

**Ард иргэд COVID-19-ийн шинжилгээнд хангалттай хамрагдахгүй байна.**

**COVID-19-ийн тархалтыг таслан зогсоохын тулд шинж тэмдэг илэрсэн хэн боловч шинжилгээнд хамрагдах хэрэгтэй байна.**

**Би шинжилгээнд хамрагдах ёстой юу?**

- Хэрэв танд уг өвчний шинж тэмдэг илэрч байгаа бол шинжилгээнд хамрагдвал зохино. Халуурах, ханиалгах, хоолой хөндүүрлэх/загатнах, амьсгал давчдах, амт үнэр мэдэхгүй болох гэх шинж тэмдгээр уг өвчин илэрнэ.
- Та хэдийгээр маск зүүдэг, мөн олон хүмүүстэй харьцдаггүй ч гэсэн уг өвчний шинж тэмдэг илэрвэл та шинжилгээнд хамрагдвал зохино.
- Хэрэв та уг өвчний дэгдэлттэй газруудаар зорчсон бол доорх веб хуудсан дэх зөвлөмжийг дагаж мөрдөнө үү:  
<https://www.nsw.gov.au/covid-19/latest-news-and-updates#self-isolate-and-get-tested-immediately-if-youve-been-to-these-locations>

**Шинжилгээ өгөх нь аюулгүй юу?**

- Шинжилгээг өгөх клиник эмнэлгүүд нь ариун цэврийн болон аюулгүй байдлыг бүрэн хангасан. Шинжилгээ өгөхөд ямар ч аюулгүй.

**Шинжилгээ үнэ төлбөртэй юу? Надад Медикэр карт байх хэрэгтэй юу?**

- Улсын эмнэлгүүдэд шинжилгээ өгөх нь үнэ төлбөргүй. Та заавал Медикэр карттай байх хэрэггүй.

**Би хаана очиж шинжилгээ өгөх вэ?**

- Шинжилгээний олон клиник төвүүд бий. Шинэ Өмнөд Уэльс мужийн шинжилгээний төвүүдийн мэдээлэл дараах веб хуудсанд нийтлэгдсэн байгаа болно:  
<https://www.health.nsw.gov.au/Infectious/covid-19/Pages/clinics.aspx>
- Та урьдчилан цаг авалгүйгээр улсын шинжилгээний клиник төвүүд дээр шууд очиж болно.
- Зарим төвүүд руу та шууд явган очиж болно. Зарим төвүүдэд машинаасаа буулгүйгээр үйлчлүүлэх боломжтой.

- Орчуулгын үйлчилгээ авах боломжтой. Таныг ирэхэд шинжилгээний төв орчуулагч захиалж танд үйлчилгээ үзүүлэх боломжтой.
- Мөн та өөрийн эмч (өрхийн эмч)-дээ хандан шинжилгээнд хамрагдаж болно. Таны эмч шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж өгөх боломжтой.

**Хүүхэд шинжилгээ өгч болох уу?**

- Тийм, хүүхэд шинжилгээнд хамрагдаж болно.
- Зарим клиник төвүүд нэн бага насны хүүхдийн шинжилгээг хийдэггүй байж болох юм. Та тухайн төв рүү утасдах буюу NSW мужийн Эрүүл мэндийн яамны веб хуудаснаас клиник төвүүдийн насны хязгаарын талаарх мэдээллийг авч болно:  
<https://www.health.nsw.gov.au/Infectious/covid-19/Pages/clinics.aspx>

**Шинжилгээ өгөхөд хэр удах бол?**

- Шинжилгээ өгөхөд маш хурдан.
- Хэрэв шинжилгээний төв олон хүнтэй байвал танд хүлээх хэрэг гарч магад юм.

**Би шинжилгээний хариугаа яаж авах вэ?**

- Ихэнх шинжилгээний хариуг текст мессэжээр явуулдаг бөгөөд хэрэв хүсвэл та төвийн өгсөн утасны дугаараар холбогдон асууж болно. Ихэнх шинжилгээний хариу 24 цагийн дотор гардаг.
- Хэрэв таны хариу эерэг гарсан бол эрүүл мэндийн албанаас тань руу утасдах болно.

**Шинжилгээ өгсний дараа юу болох вэ?**

- Шинжилгээний хариу гартал та өөрийгөө тусгаарлах хэрэгтэй. Энэ нь та гэртээ байж бусад хүмүүсээс хол байх хэрэгтэй гэсэн үг юм.

**Хэрэв би COVID-19 туссан бол яах вэ?**

- Бид тантай утсаар холбогдон нэмэлт асуултууд асуух бөгөөд танд юу хийвэл зохихыг хэлж өгөх болно.
- Та гэртээ 14 хоног байх хэрэгтэй бөгөөд энэ хугацаанд бусад хүмүүсээс хол байх хэрэгтэй.
- Ихэнх хүмүүст эмнэлэг явах юм уу зочид буудалд тусгаарлагдах хэрэг байдаггүй.
- Эрүүл мэндийн систем танд тусламж дэмжлэг үзүүлэх болно. Хэрэв танд эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлага гарсан бол таныг үнэ төлбөргүй эмчлэх болно.

# Information about COVID-19 testing clinics

## Not enough people in the community are getting tested for COVID-19.

## Everyone with symptoms needs to get tested to help stop the community spread of COVID-19.

### Should I get tested?

- If you have any symptoms you should get tested. Symptoms include fever, cough, sore/ scratchy throat, shortness of breath, loss of taste or smell.
- Even if you wear a mask and don't see many people, you should still get tested if you have symptoms.
- If you have been to an area of concern, follow the advice on this website:  
<https://www.nsw.gov.au/covid-19/latest-news-and-updates#self-isolate-and-get-tested-immediately-if-youve-been-to-these-locations>

### Is it safe to get tested?

- The testing clinics are clean and safe. It is safe to get tested.

### Do I have to pay to get tested? Do I need a Medicare card to get tested?

- In a public clinic, it is free to get tested. You don't need a Medicare card.

### Where can I get tested?

- There are many testing clinics. This website shows the testing clinics in NSW:  
<https://www.health.nsw.gov.au/Infectious/covid-19/Pages/clinics.aspx>
- You can just turn up at a public clinic. You don't need to make an appointment.
- Some clinics you can walk into. Other clinics are drive-through clinics.

- Interpreters are available. The clinic can arrange a telephone interpreter when you arrive.
- You can also ask your GP (local doctor) about testing. GPs can arrange testing.

### Can children get tested?

- Yes, children can get tested.
- Some clinics may not test very young children. You can call the clinic or check the NSW Health website for age limits:  
<https://www.health.nsw.gov.au/Infectious/covid-19/Pages/clinics.aspx>

### Does it take long to get tested?

- The test is very quick.
- If the clinic is busy you might need to wait to be tested

### How will I get my results?

- Most test results are sent by text message or you can call the number provided by the clinic. Most results are available in less than 24 hours.
- If your test is positive, the health service will call you.

### What happens after I get tested?

- You need to self-isolate until you get your results. This means you need to stay at home, away from other people.

### What happens if I have COVID-19?

- We will call you, ask you more questions, and tell you what to do.
- You will need to stay home for 14 days, away from other people.
- Most people don't need to go to hospital or a quarantine hotel.
- The health system will support you. If you need treatment in hospital there will no cost to you.